

**УЛСТӨРИЙН ОНОЛ, ФИЛОСОФИ, ҮЗЭЛ СУРТАЛ ГЭЖ ЮУ ВЭ?****Ё.Довчин** доктор, тэргүүлэх профессор

МУИС, НШУС, Улстөр судлалын тэнхмийн эрхлэгч

**Түлхүүр үг:** улстөрийн онол, улстөрийн философи, улстөрийн шинжлэх ухаан, улстөрийн үзэл суртал

**Товч агуулга:** Эл өгүүлэлд улстөрийн онол бие даасан мэдлэг ухааны салбар болж хөгжихдөө туулсан зам, философи, үзэл суртал, практикийн холбоо хамаарал, түүний судлах зүйл, асуудлуудыг тоймлон авч үзэж судлаачдын анхаарлыг хандуулахыг зорьсон болно.

XX зууны эцэс XXI зууны эхэн энэ цаг үед улстөр судлаачид улстөрийн шинжлэх ухааны мэдлэг, түүний дотор улстөрийн онолын өнгөрсөн түүхийг эргэн харж өнөө, ирээдүйг нь эргэцүүлж байгаа нь зүйн хэрэг.

Дэлхийн II дайнаас хойш 1970-аад оныг хүртэл энэхүү сэдэв “улстөрийн онол”, “улстөрийн философи”, сүүлийн үед “улстөрийн үзэл суртал” хэмээн нэрийдэж иржээ. Хэдийгээр үзэл бодлын зөрүү байсан ч энэ үед улстөрийн онолын бүтцэд нэг талаас улстөрийн сэтгэлгээний түүх, нөгөө талаас аналитик улстөрийн онолыг хамруулах тал дээр харьцангуй зөвшилцөлд хүрсэн байсан гэж болно. 1970-аад оны эхээр Роулсын “Шударга ёсны онол” бүтээл гарснаар 1980-аад оны сүүл хүртэл улстөрийн норматив онол ноёрхох байр суурь эзэлж эхэлсэн нь тодорхой байдаг. Энэ нь улстөрийн онол “том” норматив онолын эх хөрсөнд эргэж буулаа гэдгийг улстөрийн онолын хүрээнийхэн хүлээн зөвшөөрсөн хэрэг байв.

Гэвч 1990-ээд оноос хойш ялангуяа сүүлийн хэдэн жилд улстөрийн онолын талаар зарим эргэлзээ төрж, улстөрийн онол хэмээх нэр томъёоны талаар ч мэр сэр мэтгэлцэх болжээ. Үүнд хэд хэдэн хүчин зүйл нөлөөлсөн байж болох юм. Нэгдүгээрт, улстөрийн шинжлэх ухаан, улстөрийн эмпирик онол 1945 оноос нааш дэлхий дээр болж өнгөрсөн улстөрийн томоохон үйл явдлуудыг урьдчилан таамаглаж чадаагүй гэсэн шүүмжлэл гарах болсон. Тухайлбал, 1960-аад оны оюутны үймээн, иргэний эрхийн хөдөлгөөн, түүнчлэн шинэ фундаментализм, социалист системийн задрал, 1980-аад оны шувтаргын тайван хувьсгал зэрэг нь улстөр судлаачдын хувьд гэнэтийн санаандгүй зүйл байв. Хоёрдугаарт, улстөрийн онолын шинэ чиглэлүүдийн нийтлэг тал нь “үнэнийг олох дотоод логик” гэхээсээ илүүтэй нийгмийн зорилго, ашиг сонирхлыг судалгааны гол хөтлөгч болгож улстөрийн дискурс дэх нийгмийн шинж төлөвөөс эх авах болсонд оршино. Энэ нь улстөрийн онолын парадигмын шилжилтийг шаарджээ. Гуравдугаарт, улстөрийн шинжлэх ухааны чухал чухал асуудлуудад сорилт тулгарч, уул сэдвүүдээр өргөн мэтгэлцээн хэлэлцүүлэг өрнөх болсон. Улстөрийн төвийн удирдах чадвар, чадамж, үндэсний төр улс улстөрийн нэгж байх тухай ойлголт, төрийн оролцооны эерэг сөрөг тал, иргэний нийгмийн шинэ бүрдэл, орчин үеийн нийгмийн соёлын олон янз байдал улстөрийн онолын судлах зүйлд зайлбаргүй нөлөөлөх болсон. Дөрөвдүгээрт, дурдсан асуудлууд улстөрийн онол гэж юу вэ? гэсэн асуултыг шууд, шууд бус хөндөж, улстөрийн онол, үзэл суртал, философи гэсэн үгсийн утга давхцах, зөрчилдөх зэргээр янз бүр хэрэглэгдсээр ирсэн нь бас нэг шалтгаан болжээ. Улстөрийн онол философоос ялгаатай юу? Улстөрийн философи үзэл суртал хоёр адил уу? Улстөрийн онол улстөрийн шинжлэх ухааны дэд салбар уу, эсвэл түүнтэй ойролцоо утга агуулгатай юу? Түүнчлэн улстөрийн онол үзэл санааны

түүхийн нэг тал уу? Аль эсвэл бусад мэдлэг ухааны салбаруудын бүрдлүүд холилдсон гибрид шинжтэй судалгааны хүрээ юү? Учир нь өнөөдөр улстөрийн онол, түүх, ёс зүйн философи, сэтгэл судлал, олон улсын харилцаа, хууль, эдийн засаг огтлолцож байдаг нь бодит зүйл. Эдгээр салбар улстөрийн онолыг улам баяжуулж байна уу, аль эсвэл ядууруулж байна уу? гэх мэт олон асуулт урган гардаг. Мэдээж сайхь асуултуудад даруй бүрэн дүүрэн хариулт өгөх бололцоогүй учир гагцхүү энд асуудал байна гэдгийг дурдаж буй хэрэг.

Ер нь "улстөрийн онол" хэмээх эл холбоо үг одоогийн бидний ойлгож хэрэглэж байгаа утгаар бол тийм ч эртнийх биш юм. XIX зуунд "онол" гэдэг үгийг таавар, таамаглал, шалгагдаагүй баримт гэсэн утгаар баахан басамжилж тохуурхсан өнгө аясаар ашиглаж байсан байна. Онол эрт цагаас философитой холбогдсон нь философи сэтгэлгээ, философи мэдлэгийн өөрчлөлт хувьсалтай уялдаатай байсан бөгөөд улстөрийн онол энэ утгаараа философи сэтгэлгээний олон салаа мөчрийн, тухайлбал, идеалист, феномонологи, экзистенциал, герменевтик, постструктуриал, марксист болон аналитик философийн тусгал болж байжээ.

Улстөрийн онолын юун түрүүнд нүдэнд өртөх шинж нь нэг талаас философи хийсвэр сэтгэлгээний хүрээ, нөгөө талаас улстөрийн практик хүрээ хоёрын хооронд оршиж, эдгээр нь хоорондоо далд зөрчилдөж байдаг орших ажээ.

М.Сандел "философи бидний ёс суртхууны эрмэлзлийг зоргоор нь тавьж болно. Харин улстөр бол зоргоор загнадаг баримтуудтай ажилладаг" гэсэн байна. Гэхдээ улстөрийн онол ямар нэг хэмжээгээр улстөрийн практикт, тухайлбал, институт, бодлого, үйл явцад ойр дөт байдаг гэж үзэх нь бий. Иймд улстөрийн институт, бодлого нь үзэл санааны, тодруулбал "амьд" онолын биелэл гэвэл дэгэсдүүлсэн болохгүй нь лавтай. Энэ тохиолдолд улстөрийн онолчдын үзэл, сонгодог бүтээлүүдийн үнэ цэнэ, ач холбогдлыг товойлгон үзэх хэрэгтэй болдог.

Өрнөдөд онол, практикийг нарийн зааглаж, онол бол улстөрийг танин мэдэх арга зүй гэдэг талаас авч үзэх нь бас цөөнгүй байна. Чингэж онол практикийг ялгаж салгадаг нь Европ сэтгэлгээнд эртний улбаатай гэж болно. Аристотель, Кант, Гегель, Маркс бүгдээрээ онолын ба практик мэдлэгийн хүрээг зааглаж байсан бол XX зууны улстөрийн философид ч байдал иймэрхүү байсан ажээ.

Улстөрийн үйл ажиллагаа нь бодож боловсруулсан рациональ итгэл үнэмшлээс төрж гардаг зүйл биш. Энэ нь үйл байдлын оршин буй уламжлалаас үндсээ авна. Практик мэдлэг бол уламжлал дотор ууссан байдаг (Oakeshott, 1991). М.Оакешотын үзснээр, бодит байдлыг онолууд бус, харин өдөр тутмын практик шийдвэрүүд өөрчилж байдаг бол Л.Штраус "Улстөрийн философи нь чанагуухь үнэний ертөнцийг нээхийг шаардах бөгөөд улстөрийн шинжлэх ухаан, бодлого, үзэл суртлын бохир, хувийн ашиг сонирхлоо урьдал болгодог хүрээ хийгээд релятивизм, нигилизм, историцизмын ёроолын аюулт хад цохионы аль алинаас зайлсхийх ёстой" гэж "Улстөрийн философи гэж юу вэ?" өгүүлэлдээ бичжээ. Энэхүү улстөрийн философийн чанагуух, түүхэн бус хүрээ байх шаардлага нь Ж.Роулс, Р.Нозик, Р.Дворкин нарын бүтээлд тусгалаа олсон хэдий ч тэд өөрсдийнх нь хийсвэр онолууд өдөр тутмын улстөр, улстөрийн бодлого боловсруулахад нөлөөтэй гэж үздэг байна.

Энэ бүхнээс эргэцүүлбэл, онол хоосноос гарч ирдэггүй. Онол практикаас эх авч улстөрийн хүрээний зураглалыг гаргаж бидний хааш явахыг зааж хөтөлдөг ажээ. Иймд улстөрийн сайн онол хэрэглэн улстөрийн практикийг өөрчилж сайжруулж болно гэж хэлэх үндэстэй аж. Үүнээс үзэхэд улстөрийн онолыг улстөрд хэрэглэх боломжтой системчлэгдсэн үзэл санаа, үнэлэмжүүдийн нийлбэр цогц гэж томьёолох нь зүйд нийцэх болов уу. Улстөрийн онолын мэдлэг улстөрийн практиктай сүлжилдэн оршдог учраас улстөр ихэвчлэн төр, түүний дотор засгийн

газар, хууль тогтоох байгууллага, төрийн бодлого гэсэн нэр томъёонуудад төвлөрдөг. Төрийг янз бүрээр ойлгож тайлбарлаж байсан ч тэр нь саяхан болтол орчин үеийн улстөрийн олон онолын нийлж огтлолцох цэг болж байв. Харин улстөрийг тэгш байдал, рациональ шинж, шударга ёсны ойлголтуудтай нэн түрүүнд холбон үздэг норматив онолд тулгуурласан улстөрийн онолын хандлага сүүлийн үед л хүчээ авсан түүхтэй. Энэхүү онол үнэлэмжийн жишиг, үйл байдлын заагдсан хэлбэрүүд, институциональ бүтцүүдийн санал болгосон хэлбэрүүд зэрэгт юуны өмнө анхаарлаа төвлөрүүлдэг. Энэ утгаар улстөрийн онол ёс зүйн онолтой нягт холбогдож зарим онолчид ёс зүйн ба улстөрийн онолыг тод зааглаж байхад бусад нь ёс зүйн болон улстөрийн үндэслэгээ хоорондоо нягт харилцан хамааралтай гэж үздэг байна. Түүнчлэн зарим судлаачид норматив онол нь "том" онол эргэн ирсний" илэрхийлэл болсон гэх нь ч буй. Уг чанартаа норматив онол бол сүүлийн 30 жилийн их мэтгэлцээн, үндэслэл нотолгоог агуулсан нарийн нийлмэл ухагдхуун байсан. Өнөөгийн маргаан мэтгэлцээний төвд буй норматив онолуудад либерализм ба либертарианизмын янз бүрийн хэлбэрүүд, коммунитаризм, феминизм, хүмүүнлэгийн ба аналитик марксизм, республиканизм орно.

Улстөрийн норматив онол дотор шийдвэрлэх цөөнгүй асуудлууд байдгаас хамгийн түрүүнд онолыг чухам ямар суурь дээр босгох вэ гэдэг юм. Роулс мэтийн сэтгэгчид метафизикийг хувийн хүрээнд шилжүүлэхийг хичээсэн боловч энэ нь үнэн зөв эсэх нь эргэлзээтэй ажээ. Учир нь метафизик нь мухар сүсэг, итгэл үнэмшилтэй адилгүй. Фиолсофи хүний уг чанарын тухай ихээхэн хийсвэр итгэл үнэмшил дээр суурилдаг гэж эрдэмтэд үздэг. Иймд метафизикээс зугатах эсвэл түүнийг шүүрдэж зайлуулах нь амаргүй бололтой. Метафизик нь тухайлбал, нотолгоо дүгнэлттэй уялдсан үнэмшил магадлал бүхий таамаглалуудтай холбоотой. Ийм суурь таамаглалууд улстөрийн онолд цэвэр улстөрийн шинжтэй байдаг. Ийнхүү тодорхой суурь таамаглалуудыг үндэслэн норматив онол улстөрийн дэг журмыг суурь үнэт зүйлсийн дагуу хэрхэн тогтоож болохыг нээж харуулахыг оролддог ажээ. Өөрөөр хэлбэл, институтууд, улстөрийн үйл явц суурь таамаглалуудаас хэрхэн урган гарч, хэрхэн зөвтгөгдөж байгааг үзүүлнэ.

Ийнхүү улстөрийн онол философи, улстөр хоёрын хооронд оршиж, хоёулангаас нь шим тэжээл авдаг боловч алинтай нь ч адилгүй ажээ. Орчин үеийн улстөрийн ихэнх онол хэт хийсвэр, улстөрийг гүнзгийрүүлэн тайлбарлахдаа харам байна гэдэг нь үнэний хувьтай. Улстөрийг тайлбарлах өвөрмөц хэлбэр байхын тулд онол улстөрийн практикаас тодорхой зай барих хэрэг гардаг. Иймээс "Онолыг практикаас хэт тасархай гэж буруутгах нь үргэлж маргаантай, ихэнхдээ шударга бус байдаг" (Galston, 1993, 32). Жишээ нь, либерал-коммунитаричуудын мэтгэлцээн, Роулсын сүүлийн бүтээлийн ("Улстөрийн либерализм" 1993) үзэл санаа үүнийг гэрчлэх болов уу. Тухайлбал, Роулс норматив бүтцийн тоосго нь болж өгдөг сайн эрэмбэлэгдсэн нийгэм, ёс суртхуунтай хувь хүн нь либерал ардчилсан нийтлэгийн нийтийн соёлоос гарвалтай хэмээн үзсэн. Иймд онол бол үнэлэлт өгөх шаардлагатай жинхэнэ институт, бодлогын шинж төлөвийг шилж сонгох, дэс дараалалд оруулахад бидэнд тус үзүүлэх ерөнхий хүрээг тогтоодогоороо онцлог гэж болох юм.

Одоо улстөрийн онолтой холбож үзэл суртлыг товч авч үзье. Үзэл суртал бол 1800-аад оны эхэн үеэс гарч ирсэн харьцангуй шинэ үг. XIX зууны сүүл хүртэл төдийлөн дэлгэрч чадахгүй байсаар XX зуунд улстөрийн дискурст өргөн хэрэглэгдэх болжээ. Анх Дестют де Траси үзэл суртлыг "үзэл санааны шинжлэх ухаан" гэсэн утга санаагаар авч үзсэн бол үзэл суртлын онолыг үндэслэгч К. Маркс түүний яг эсрэгээр үзэл суртлыг хуурамч ухамсрын хэлбэр, хэсэг хүмүүсийн өөрсдийгөө завтгөхөөр хоосон зохиосон зүйл гэжээ. К.Манхейм ч үзэл суртлыг хуурамч

төсөөллүүдийн нийлбэр цогц гээд харин түүнийг түүхийн үүднээс шинжлэхийг чухалчилсан байдаг. Үүний сацуу үзэл суртал хэмээх ойлголт эхнээсээ улстөрийн утга санаа агуулж байсныг хэлж болно. Жишээ нь, Дестют де Траси өөрийн "үзэл санааны шинжлэх ухаан"-аас олж авсан мэдлэгийг нийт нийгэмд ашиглаж, чингэснээр хүмүүсийн аж амьдралыг сайжруулахыг эрмэлзэж байжээ.

Орчин үеийн улстөрийн онолд үзэл сурталын асуудлаар хэл амаа ололцсон нь бага. Өнөөдөр ч үзэл суртал маргаан будлиантай ойлголт хэвээр үлдэж түүнийг янз бүрийн утга агуулгаар хэрэглэж байна. Жишээлбэл, үзэл суртал хувь хүний улстөрийн үзэл бодол, улстөрийн нам, хөдөлгөөний үзэл баримтлал, эсвэл ертөнцийг үзэх үзлийг заадаг. Л.Саргент үзэл суртал бол "шүтэн бишрэгчддээ юу болох, ямар байх ёстой талаар ертөнцийн зургийг дүрслэн үзүүлж... чингэхдээ ертөнцийн тоймгүй ээдрээ түвэгийг энгийн хялбар бөгөөд ойлгомжтой буулгаж өгдөг" гэж тодорхойлжээ. (Sargent, 1972,1). Үзэл сурталын талаархи судлаачдын өөр өөр байр суурийг жишиж харьцуулан уг ойлголтын тодорхойлогч шинжүүдийг Л.Барадат дурдахдаа, нэгдүгээрт, үзэл суртал бол өөр утга санаагаар хэрэглэгдэж болох ч юуны өмнө улстөрийн нэр томъёо мөн. Улстөрийн мөн чанар нь түүнийг улстөрийн утга агуулгаар түүхийн турш хэрэглэж ирсэнтэй холбоотой. Хоёрдугаарт, үзэл суртал болгон өнөө болон ирээдүйн тухай төсөөлөл, дүр зургаас бүтдэг. Итгэл найдвар төрүүлж байдаг нь үзэл сурталын нэг гол шинж байдаг. Гуравдугаарт, үзэл суртал үйл хөдлөлийг баримжаалж байдаг. Өнөөгийн бодит байдлыг тодорхойлж, сайхан ирээдүйг санал болгоод зогсохгүй, хамгийн чухал нь зорилгод хүрэх алхмуудын талаар тодорхой чиг удирдамж өгдөг. Дөрөвдүгээрт, үзэл суртал олон түмэнд хандаж, асар олон хүнийг дайчлахыг зорино. Тавдугаарт, үзэл суртал олон түмэнд чиглэдэг учраас жирийн хүмүүст ойлгомжтой энгийн хялбар үг хэллэгийг гол төлөв ашигладаг гэжээ (Baradat, 1991,9).

Гэвч үзэл сурталын талаар зонхилогч интерпретаци нь нэлээд басамжлах өнгө аяс агуулсаар ирсэн. Үзэл сурталд улстөрийн философийн үнэт зүйлс байдаггүй гэдэг. Үзэл суртал бол улстөрийн оролцогчдыг ятгах, төөрөгдүүлэх, эцсийн бүлэгт улстөрийн эрх мэдэлд хүрэх зорилгоор үзэл санаануудыг зохиодог ажээ. Жишээ нь, Л.Штраус улстөрийн философи ба үзэл сурталыг тодорхой зааглаж байв. Түүнийхээр философи бол бурхан, ертөнц, хүний мэдлэг- түгээмэл мэдлэгийн хийгээд мэргэн ухааны өнө эртний эрэл хайгуул байжээ. Өөрөөр хэлбэл тэрбээр философи нь үзэл сурталтай харьцуулахад зүйрлэшгүй ариун нандин дээд мэдлэг гэсэн санааг хамгаалж байгаа нь илэрхий байна.

Улстөрийн үзэл суртал мэдлэг, санал бодлын ялгааг үл тоодог хэр нь домгийг шүүж тунгаалгүй дэмждэг гэж бас хэлэлцдэг. Иймээс "орчин үед улстөрийн философи үзэл суртал тийш хэлтийсэн" (Vincent, 1997,18) гэдэг нь энэ бүхэнтэй холбоотой байна.

Түүнээс гадна философи, үзэл суртал, онолыг улстөрийн мэдлэгээс ангид авч үзэхийг оролдож байсан нь норматив онолыг ойшоохгүй болсон үеийн тусгал байсан гэж ч болно. Логик позитивизм дүгнэлтүүдийг хэв маягаар нь ялгаж, эмпирик дүгнэлтүүд байгалийн шинжлэх ухаанд л хамаатай бөгөөд харин философи байгалийн шинжлэх ухаантай харьцуулахад нэгдүгээр зэргийн мэдлэг байж чадахгүй гэж үзсэн. Дүгнэлтүүдийн нөгөө нэг хэв маягийг "норматив" хэмээн нэрлэж, тэдгээр нь ертөнцийн тухай юу ч хэлж чадахгүй, гагцхүү хувь хүмүүсийн сэтгэлийн хөдөлгөөн, сэтгэл зүйн байдлыг илтгэдэг. Энэ утгаар үзэл суртал шууд сэтгэл хөдлөлийн хүрээнд хамаарагдана. Мөн логик позитивизмоор бол философи зөвтгөх, зааж зааварлах ёсгүй бөгөөд үүгээрээ үзэл сурталд байж болох шууд норматив шаардлагуудаас ялгаатай. Иймд үзэл суртал нь ямар нэг үндэслэгээнд тулгуурлаагүй зөвхөн зааж зааварласан шинжтэй номлол болж байна.

Үзэл суртал философи харилцан холбоотой ч үзэл суртал түүнээс гурван шинжээрээ ялгаатай ажээ. Нэгдүгээрт, философи гүнзгий, ертөнцийн ээдрээтэй бүхэнд нэвтрэхийг оролддог бол үзэл суртал гүехэн, түвэгтэй бус. Хоёрдугаарт, үзэл суртал хувь хүн гэхээсээ асар олон хүмүүст ханддаг. Гуравдугаарт, ертөнцийг энгийн тайлбарлахын сацуу үзэл суртал аж амьдралаа сайжруулах шийдвэртэй алхам хийхийг хүмүүсээс шаардаж, даруй үйл хөдлөлд тэднийг уриалдаг ( Baradat, 1991.10).

Зарим судлаачид улстөрийн уламжлалт онолыг улстөрийн амьдралын өнөөгийн асуудлуудаас тасалсныг үзэл сурталыг үгүйсгэсэнтэй холбож үзсэн байна. Р.Ашкрафт, одоогийн улстөрийн асуудлуудад хандахдаа зөвхөн үзэл сурталд суурилснаар л улстөрийн философийн уламжлал, "улстөрийн" үзэгдлүүдийн ойлгоц хоёрын хооронд гүүр тавих бололцоотойг тэмдэглэжээ (Ashcraft,1975,20). Чингэснээр үзэл суртал ба улстөрийн философи хоорондоо онцын ялгарах зүйлгүй болж, үзэл суртал нь ердийн хоосон гоё үгнээс эхлээд философийн асуудлууд хүртэл олон төвшинд шилждэг дотооддоо нарийн нийлмэл үзэл санаа гэсэн дүгнэлтэд хүргэжээ. Ашкрафтын ийм байр суурь улстөрийн философчдыг улстөрийн үзэл сурталчид болгож, философи нь үзэл сурталтай харьцуулахад илүү эрхэм дээд, гэгээлэг гэдгийг үл тоосон гэж шүүмжлэгддэг. Ийнхүү үзэл суртал, түүний улстөрийн онолтой холбогдох тухайд судлаачдын санал нэг мөр болж чадаагүй бөгөөд ойлгомжгүй зүйл багагүй байгаа нь илэрхий байна.

Улстөрийн онолын хөгжил ХХ зуунд ямар зам туулав? Аливаа онолын нэг адил улстөрийн онолын үндсэн бүрдвэр нь ойлголт ухагдхуун мөн. Иймээс улстөрийн онолыг улстөрийн хэлний хөгжилтэй холбон авч үзсэн байдаг нь учиртай. Тухайлбал, эрдэмтэд (Бергман, Рорти) үүнийг "хэл шинжлэлийн эргэлт" гэсэн нэр томъёогоор илэрхийлсэн байна. 1920-иод оны сүүлээр логик позитивизмын хэл ноёрхож байх үед улстөрийн болон улстөрийн онолын хэлийг цэвэрлэж түүнийг утга агуулга төгс, будлиангүй, ончтой болгохыг зорьж байжээ. Улстөрийн онолын хэл аналитик, синтетик, үнэлэмжийн нотолгоонуудын хольц болж, дээр үеэс "баримтууд" ба "үнэлэмж"-ийг хольж хутгасаар ирсэн гэж үзэж байв. Түүгээр ч барахгүй улстөрийн онолын ийм субъектив, зохиомол шинж нь нийгмийн шинжлэх ухаан, түүний дотор улстөрийн шинжлэх ухааны хөгжилд таагүй нөлөөлсөн гэсэн шүүмжлэл ч гарсан. Энэ байдлаас гарах улстөрийн онолын ганц найдвар нь түүний хэлийг цэвэрлэн, шинжлэх ухааны хэлний төвшинд хүргэн, ойлголтуудыг танин мэдэхүйн утга агуулгатай болгоход оршино. Тиймээс тэр үеийн улстөрийн онолын тэргүүн зорилго нь улстөрийн шинжлэх ухааны ойлголтуудыг тодруулах, улстөр судлаачдын ашиглаж хэрэглэдэг улстөрийн нэр томъёонуудыг ончтой зөв тодорхойлоход оршиж байжээ (энэ үеийг "ойлголтуудын шинжилгээ" гэж нэрлэх нь бий). Иймээс 1950-60-аад оны улстөрийн онолчид уламжлалт буюу норматив онолын нэр томъёог дахин тодорхойлох, тэдгээрийг шинжлэх ухааны эмпирик шинжилгээ болон улстөрийн үйл байдлыг тайлбарлахад тохируулж хэрэглэхийг чармайсан байна.

Улстөрийн онол дахь "хэл шинжлэлийн эргэлт"-ийн дараачийн шат нь "энгийн хэл"-ний философи гэж нэрлэгддэг. Энэ үе нь өмнөх позитивистуудыг хурц шүүмжилж, харин улстөрийн онолын өнгөрсөн, эдүгээд нааштай хандаж байв. Байгалийн шинжлэх ухааны хэл нь нарийн тодорхой, танин мэдэхүйн утга санаа гаргах жишиг байж чадахгүй. Улстөрийн хэл бүрхэг, тодорхой бус байдаг нь улстөрийн дискурсын шинж чанартай холбоотой гэж тайлбарлаж байжээ.

"Улстөрийн дискурс" гэдгийг улстөрийн хэл, улстөрийн ойлголтуудын хувьсал өөрчлөлт, тэдгээрийн талаархи ойлголтын зөрүүг тусгасан улстөрийн коммуникацийн үйл явц гэж ойлгож буйг энэ дашрамд тэмдэглэж байна. Энгийн

хэлний шинжилгээ нь хэн нэгнийг үйл хөдлөлд түлхсэн улстөрийн заавар зөвлөмж, ёс суртхууны захирамж тушаал өгдөггүй. Жишээ нь, шударга ёсны ойлголтыг сонирхоно гэдэг бол шударга бус явдлыг илчлэх, эсвэл шударга ёсыг давуутай харуулна гэсэн үг биш юм. Харин улстөрийн онолч нь хүмүүс ойлголтыг ашиглаж нийгмийн зохион байгуулалтыг шүүмжлэх, эсвэл магтах үедээ тэд юу бодож байдгийг зөвхөн тодруулж тайлбарлах зорилготой ажээ. Энгийн хэлний философи улстөрийн мөргөлдөөн ба ойлголтын маргаантай байдлыг ихэнхдээ дутуу анхаарч, чингэснээр “хэл шинжлэлийн” үед улстөрд хайхрамжгүй хандаж байсан гэж судлаачид үздэг байна.

Хэл шинжлэлийн философийн позитивист ба энгийн хэлний хувилбарууд нь ойлголтын маргаант байдлыг цэгцлэх, түлхүүр ойлголтуудыг дахин нарийвчлан тодорхойлох зорилтуудыг хүлээн зөвшөөрч байжээ. Улстөрийн дискурсын зарим ойлголтууд угаасаа маргаант шинжийг агуулдаг гэсэн үзэл санаа бас дэлгэрч байжээ. Эл үзлээр улстөрийн амьдралын гол шинж чанар нь гүнзгий зөрчил мөргөлдөөн, санал зөрөлдөөнөөр илэрдэгт орших ажээ. Гэвч энэ санааг сөргүүлж улстөр бол дан мөргөлдөөн, зөрчилдөөн бус улстөрийн дискурст бас хэлцэл тохиролцоо, зөвшилцөл байдгийг товойлгож тавьсан чиглэл гарч ирсэн. Энэ чиглэлийн төлөөлөгчид ойлголтын угийн маргаант байдал улс төрийн дискурсын шинж гэдгийг үгүйсгээгүй ч ойлголт бүрт ийнхүү хандах нь улстөрийн ойлголтын шинж чанар, үүргийг цаг хугацаа, түүхээс салангид авч үзэж байна гэсэн үг. Гэтэл хэрэг дээрээ бүх ойлголтууд бүх цаг үед маргаантай байх албагүй. Ойлголт маргаант шинжтэй байлаа ч тэр нь гагцхүү цаг хугацааны давтамжтай байдаг. Өөрөөр хэлбэл улстөрийн дискурсын хэл уг чанартаа маргааны өнгө аясыг агуулдаг боловч аливаа улстөрийн хэлийг бүрэлдүүлэгч тухайн ойлголтуудын маргаант шинж зөвхөн үе үе идэвхждэг байна. Маргаж мэтгэлцэх, засч залруулахад байнга өртдөг ойлголтууд нь философийн гэхээсээ үргэлж улстөрийнх байдаг аж.

Ойлголтуудын маргаант шинж үе үе давтагддаг тухай энэ үндэслэл улстөрийн сэтгэлгээг судлах өөр нэг хандлагын тухайлбал, “улстөрийн ойлголтуудын түүх”-ийн үүдийг нээж өгдөг байна. Маргаан мэтгэлцээний явцад хуучин утга санаа нь сорилттой тулгарч, шинэ ойлголтуудын үндэслэгээнүүд дэвшигдэн гарч ирдэг. Тодруулбал улстөрийн шинэ зүйлс, тэдгээрийг дагаад ойлголтууд хувирч өөрчлөгдөгийг уул хандлага иш үндэс болгодог байна.

“Нийтлэг ойлголтууд үгүй бол нийгэм байхгүй, үүний дээр үйл ажиллагааны улстөрийн талбар ч байх аргагүй... “Зөв” ойлголтуудын төлөө тэмцэл нийгмийн болон улстөрийн хувьд тэсрэхэд хүрсэн” гэж германы улстөрийн онолч Коселлек (Koselleck, 1985, 74) бичжээ. Тэрхүү нийтээр мэддэг ойлголтууд нь түүхийн эргэлтийн үеүдэд үүсч бий болдог. Улстөрийн ойлголтуудын түүхийн шинжээчид орчин үеийн улстөрийн дискурсыг бүрдүүлэгч ойлголтуудын түүхэн дэх янз бүрийн эргэлтийн үе, түүхэн үйл явдлуудыг судлах замаар тэдгээрийн үүсэл, хувьсал өөрчлөлтийг тогтоохыг хичээж байдаг ажээ. Энэ нь шинэ, эсвэл одоо нэгэнт нийтээр мэдэх “үзэл суртал”, “либерализм”, “консерватизм”, “социализм” мэтийн үгс хэзээ, ямар зорилгоор, улстөрийн ямар орон зайд орж ирснийг төдийгүй “үндсэн хууль”, “хувьсгал” гэх мэт хуучны нэр томъёонуудын утга санаа хэрхэн өөрчлөгдснийг мөшгиж үзэхийг чухалчилдаг. Жишээ нь, XVIII зуун бол ойлголт, нэрийдлийн хэзээ ч байгаагүй их өөрчлөлт шилжилтийн үе байсныг германы судлаачид тогтоожээ. Энэ үед шинэ нэр томъёо гарч ирж, хуучин нь шинэчлэгдснээр барахгүй тэдгээр нь улам бүр үзэл суртлын хийсвэрлэл тийш эргэх болжээ. XIX зууны эхээр социализм, коммунизм, индустриализм гэх мэтийн зүсэн бүрийн “измүүд” гарч ирсэн нь хүмүүс өөрсдийгөө нийгмийн хийгээд улстөрийн орон зайд байршуулах шинэ арга хэрэгсэл болж байв. Эдгээрийн хаялгаар улстөрийн мөргөлдөөн мэдэгдэхүйц үзэл

сурталжиж, урьд өмнө тэр нь хэрэг явдал төдий байснаа одоо зарчмын асуудлуудыг илүүтэй хөндөх болжээ. Ойлголтууд өмнөх шигээ тодорхой анги бүлэг, газар зүйн хүрээгээр хязгаарлагдахаа больж чөлөөтэй хийсвэр, түгээмэл шинжтэй болж ирсэн байна. Жишээлбэл, "эрх" зөвхөн англичуудын эсвэл бусад үндэстний бүлгийн эрх биш, "эрэгтэйчүүдийн эрх", одоогийнхоор "хүний эрх" болсон жишээтэй.

Англи-америкийн сургуулийнхан яагаад үг гэхийн оронд ойлголт, "хэл шинжлэлийн" өөрчлөлт гэхийн оронд "ойлголтын" өөрчлөлт, хэл шинжлэлийн түүх гэхийн оронд ойлголтуудын түүх гэсэнд бас учир байдаг. Улстөрийн үгсийн сан дан үгсээс бус, харин ойлголтуудаас бүтдэг. Ойлголт байлаа ч түүнийг илэрхийлэх үг байхгүй байж болно. "Би эх орондоо хайртай" гэж хүүхэд хэлэхдээ илэрхийлэх үгийг мэдэхгүй ч эх оронч үзлийн ойлголтыг мэдэж байгаа хэрэг гэж Л. Фарр жишээ татсан байна. Эрхийн ойлголт үгнээс бүр эрт байжээ. Түүнээс гадна нэг үг өөр өөр цаг үед өөр өөр утгыг илэрхийлдэг. Англичуудын "эрх" нь өнөөгийн улстөрийн дэглэмүүд хамгаалдаг, эсвэл зөрчдөг тэр "хүний эрх" -тэй адилгүй. "Үзэл суртал" гарал үүслээрээ ХҮИИ зуунд үзэл санааны уг гарвалыг шинжлэх ухааны үүднээс системтэй судлах утгатай байсан бол одоо ямар нэг хэмжээгээр нягт системчилсэн улстөрийн үзэл санаанууд, үнэт зүйлсийн нийлбэр цогц гэж тодорхойлогдох болсон. Энэ бүхнээс үзэхэд үгс өөрчлөгдөөгүй, харин ойлголт, түүний утга өөрчлөгдсөн нь ажиглагдана. Иймд үгсээс ойлголтууд илүү өөрийн түүх намтартай ажээ. Гэхдээ улстөрийн ойлголтуудын түүхийг угаасаа холбоотой улстөрийн зөрчил мөргөлдөөнөөс ангид авч үзэх аргагүй. Ийнхүү улстөрийн ойлголтууд дайны зэвсэг, ятгаж үнэмшүүлэх арга хэрэгсэл, эв нэгдлийн бэлэгдэл болж иржээ.

Ойлголтуудын түүх нь тухайн цаг үед тухайн улстөрийн орон зайд тухайн үйл хөдлөлийг үйлдэхэд ойлголтууд хэрхэн үүсч ашиглагдав гэдэг үндэслэгээнд илүүтэй анхаардагаараа философос ялгаатай. Улстөрийн ойлголтуудын түүх нь товчоор улстөрийн үндэслэгээнүүд, мөн ойлголтуудын маргаан, мэтгэлцээний түүх ажгуу (Ball, 1997, 41-42). Гэхдээ тодорхой ойлголтуудын шинжилгээ ерөнхий норматив бүтцүүдийг боловсруулахтай зэрэгцэн онол үүсгэх чадвартай хэлбэр хэвээр үлдсэн гэж эрдэмтэд үздэг.

**Ашигласан ном зохиол**

1. Ashcraft, R. 1980. 'Political Theory and the Problem of Ideology', Journal of Politics, 80.
2. Ball, T. 1997. 'Political Theory and Conceptual Change', Political Theory. Tradition and Diversity. Cambridge University Press.
3. Baradat, L. 1991. Political Ideologies. Their Origins and Impact. 4th ed. USA.
4. Galston, W. 1993. 'Political Theory in the 1980s: Perplexity Amidst Diversity', Political Science: The State of the Discipline II. Ed. by W. Finifter.
5. Koselleck, R. 1985. Futures Past: On the Semantics of Historical Time. Cambridge.
6. Sargent, L. 1972. Contemporary Political Ideologies. USA. Dorsey Press.
7. Vincent, A. 1997. 'Introduction', Political Theory. Tradition and Diversity. Cambridge University Press.

**Abstract**

In the article, the author intended to reveal interdependence and specifics of the categories of political theory, political philosophy and political ideology. Political theory development and various concepts of fundamental researchers in the West are being compared in the article. Linguistics role in political theory, development and relationship between words and concepts are being defined.